



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/114

Хэрлэн сум

“Ид шидийн орон Хэнтий хүүхэд
хөгжил хамгааллын төв” төсөлд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Хүүдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хорин гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр-Иргэний нийгмийн байгууллагаар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх зорилгоор “Итгэл төгс нөмөр сан” төрийн бус байгууллагаар “Ид шидийн орон Хэнтий хүүхэд хөгжил хамгааллын төв” төслийг хэрэгжүүлэхэд ажил гүйцэтгэх гэрээний дагуу 17,143,000 (арван долоон сая нэг зуун дөчин гурван мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Хүүхдэд ээлтэй орон нутаг болно зардал”-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ